



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 03 өдөр

Дугаар 1/21

Жавхлант

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.1, 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1.1 дахь тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цахилгаан тасарсан тохиолдолд эрчим хүчээр тасралтгүй тэжээх цахилгааны үүсгүүр худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Алтанцэцэг Нийгмийн даатгалын улсын байцаагч

Гишүүдэд: Ч.Гантуяа Цаг уурын дарга

Нарийн бичгийн дарга: П.Цолмонбаяр Улсын бүртгэгч

2.Худалдан авах үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Алтанцэцэг), нарийн бичгийн дарга (П.Цолмонбаяр) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ЦОЛМОНБАЯР